



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай

Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг ёгч байна:

1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчтөй болсон төрийн өмчийн сролцоотой эж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад:

1.1. Иргэндээ зэлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;

1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хуний ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандaa тууштай тэмцэх;

1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: "Засгийн газрын иргэд олон нийтэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсан өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах;

1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;

1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.

2. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн язц, үр дунд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;

2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;

2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;

2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.

3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна.

4. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна.

5. Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна.

6. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт хариуцуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ